



НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2020 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 02/10

Улаанбаатар хот

“Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн
2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай”

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 “д”, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11.1 дэх заалт, 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсэг, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны 01/6524 дугаар албан бичгээр өргөн мэдүүлсэн саналыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ НЬ:

1.“Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /Д.Сумъяабазар/-д даалгасугай.

2.1.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшний хамт батлах;

2.2.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтуудыг жил бүрийн нийслэлийн төсөвт тусган хэрэгжүүлэх;

2.3.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтуудын биелэлтийг гаргаж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулах;

2.4.Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө батлагдсаны дараа түүнд суурилсан Нийслэлийн хөгжлийн жилийн төлөвлөгөөг боловсруулж Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх

3.“Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /Д.Сумъяабазар/-д үүрэг болгосугай.

1110100084

4.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, чиглэл өгч ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд даалгасугай.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН